# ОЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

Захиалагч: Байгаль орчин,
аялал жуулчлалын яам,
Ойн бодлого зохицуулалтын газар

Гүйцэтгэгч:

“Өмгөөллийн ивээл баг”
хуулийн нөхөрлөл

Улаанбаатар хот,
2022 он

**АГУУЛГА**

**ТОВЧИЛСОН ҮГ** 3

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ** 3

**УДИРТГАЛ** 4

**НЭГ.ХУУЛИЙН ЭТГЭЭД, ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ** 4-7

1.1.Хуулийн этгээд, иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох

1.2.Хуулийн этгээд, иргэнд үүсэх зардлыг тооцох

**ХОЁР.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДАЛ** 7-15

2.1.Төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг тогтоох

2.2.Ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

2.3.Гарах зардлыг тооцох

2.4.Нийт зардлын дүнг тооцох

2.5.Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

**САНАЛ ЗӨВЛӨМЖ** 15-16

**АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ** 17

## ТОВЧИЛСОН ҮГ

| | |
|---|---|
| ОтХ | Ойн тухай хууль |
| ТЗТБ | Төрийн захиргааны төв байгууллага |
| ТЗБ | Төрийн захиргааны байгууллага |



## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


| | |
|---|---|
| 1 дүгээр хүснэгт. | Хуулийн этгээд, иргэний хийх ажил |
| 2 дугаар хүснэгт. | Хуулийн этгээд, иргэний хийх стандарт ажиллагаа, зарцуулах хугацаа |
| 3 дугаар хүснэгт. | Хуулийн этгээд, иргэнд үүсэх нэмэлт зардал |
| 4 дүгээр хүснэгт. | Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг |
| 5 дугаар хүснэгт. | Төрийн байгууллагын үүргийн харьцуулалт /төсөл болон ОтХ/ |
| 6 дугаар хүснэгт. | Төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийн төрөл |
| 7 дугаар хүснэгт. | Төрийн байгууллагын нэмэлт зардлын тооцоо |

# ОЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦОО



## Удиртгал

Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-ын дагуу ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд гарах зардлын тооцоог урьдчилсан байдлаар хийлээ.

Энэхүү зардлын тооцоогоор ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэрэгжсэнээр хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг урьдчилан гаргана. Иймд хуулийн төсөлд тусгагдсан үүргийг тодорхойлох, улмаар үүргийг хэрэгжүүлэх хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад үүсэх нэмэлт зардлыг урьдчилан тооцох, эдгээр субъектэд үүсэх нэмэлт зардал, ачааллыг бууруулах хувилбарыг судлан, боломжит гарцыг санал болгохыг зорьсон.

## Нэг.Хуулийн этгээд, иргэнд үүсэх зардал

### 1.1.Хуулийн этгээд, иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох

"Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-д хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлыг үүргийг тогтоох, зардал тооцох, тоон үзүүлэлтийг тооцох, зардлын дүнг тооцож гаргах, хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах, нэмэлт зардал тооцох гэсэн зургаан үе шатаар; иргэнд үүсэх зардал, ачааллыг үүргийг тогтоох, хугацаа, зардал тооцох, тоон үзүүлэлтийг тооцох, нийт дүнг тооцож гаргах, хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах гэсэн таван үе шатаар тооцохоор тусгасан. Иргэний хувьд хуулийн төсөлд тусгагдсан үүргийг гүйцэтгэхэд холбогдон гарах мөнгөн зардлаас гадна зарцуулах хугацаа буюу ачааллыг тооцох онцлогтой юм.

"Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-ын 2.3-т "Гүйцэтгэх үүрэг гэж тухайн хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд **хуульд заасны дагуу** тоо баримт, тайлан, холбогдох бусад мэдээллийг төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх, эсхүл хүргүүлэхийг хэлнэ. Үүнд бүх төрлийн өргөдөл, хүсэлт, маягт бөглөх, статистик тоо мэдээ өгөх, бүртгүүлэх, нөхөн олговор, төрөөс тусламж, дэмжлэг, зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл гаргах, зөвшөөрөл хүсэх гэх мэт үүргүүд хамаарна" гэжээ.

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 3 дугаар зүйлээр ОтХ-ийн 23 дугаар зүйлд хоёр хэсэг нэмж, хоёр хэсгийг өөрчлөн найруулжээ. Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд явуулах, арга зүйн зөвлөгөөгөөр хангах эрхийг холбогдох хуулийн дагуу авсан аж ахуйн нэгж, байгууллагыг ойн мэргэжлийн байгууллага гэдэг байсныг өөрчилж, магадлан итгэмжлэлд хамрагдан гэрчилгээ авсан аж ахуйн нэгж, байгууллагыг ойн мэргэжлийн байгууллага байхаар тусгасан. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллагаас эрх авснаар ойн мэргэжлийн байгууллага болдог байсан бол, магадлан итгэмжлэлд хамрагдан гэрчилгээ авснаар ойн мэргэжлийн байгууллага болох зохицуулалт орсон. Энэ нь Монгол Улсын хөгжлийн бодлогын төрийн байгууллагын үйл ажиллагааны хүнд суртлыг арилгах, төрийн үйлчилгээ шуурхай, чирэгдэлгүй хүрэх, төрөөс олгох зөвшөөрлийн тоог цөөлж, олон шат дамжлагыг багасгах зорилго, зорилтод нийцсэн байна. Ойн магадлан итгэмжлэлийг төр болон хувийн хэвшлээс хараат бус төрийн бус байгууллага гүйцэтгэхээр хуулийн төсөлд оруулсан нь иргэний нийгэм-хувийн хэвшил-төрийн түншлэлийг бэхжүүлэх зарчимтай уялдсан хэмээн үзнэ.

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр хуулийн этгээд, иргэнд шинээр захиргааны үүрэг тусгайлан хүлээлгээгүй хэдий ч хуулийн төслийн $30^{1}$.1, $30^{1}$.7, $30^{1}$.8, $30^{1}$.9, 38.5-д ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажилд зөвхөн тухайн бүс, нутгийн ойн гаралтай, стандартын шаардлага хангасан ойн үржлийн материалыг тариалах, тарьц ургуулах, худалдан борлуулах, ойн үрийн нөөцийн улсын санд нийлүүлэх зориулалт бүхий үрээс дээж авч, үрийн чанарын шинжилгээг ойн үрийн төв лабораторид хийж, үрийн чанарын гэрчилгээ олгоно, гарал үүслийн болон чанарын гэрчилгээтэй ойн үржлийн материалыг худалдан борлуулна, гарал үүсэл тодорхойгүй, эсхүл үр нь лабораторийн шинжилгээгээр стандартын шаардлага хангаагүй тохиолдолд тухайн багц үрийг худалдах, импортлохыг хориглоно хэмээн заасан. ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр хуулийн этгээдэд эсхүл, иргэнд тусгайлан захиргааны үүрэг хүлээлгээгүй хэдий ч хуулийн төсөлд тусгагдсан дээрх зохицуулалт нь хуулийн этгээд, иргэний хэн алинд нь хамаарах тул хамтад нь үзлээ. 

Хуулийн этгээд, иргэн нь ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажилд гарал үүслийн болон чанарын гэрчилгээтэй модлог ургамлын үр, ойн үржлийн материалыг хэрэглэнэ. Хуулийн төсөлд модлог ургамлын үр, үржлийн материал үйлдвэрлэх, худалдах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн ТЗТБ батлахаар тусгасан. Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажлыг хуулийн этгээд, иргэний хэн аль нь гүйцэтгэж болох тул хуулийн этгээд, иргэнээс гарах зардлын хэмжээ нь адил болно. Хуулийн этгээд, иргэний хийх ажлыг[1] тодорхойльё.

1 дүгээр хүснэгт.Хуулийн этгээд, иргэний хийх ажил

| **Д/д** | **Хуулийн төслийн зохицуулалт** | **Үүргийг хэрэгжүүлэх субъект** | **Гүйцэтгэх үүрэг** |
|---|---|---|---|
| 1. | $30^{1}$.1.Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажилд зөвхөн тухайн бүс, нутгийн байгалийн ойн гарал үүсэлтэй, стандартын шаардлага хангасан ойн үржлийн материалыг тариална. | Хуулийн этгээд, иргэн | -Гарал үүслийн гэрчилгээ авах, -Чанарын гэрчилгээ авах |
| 2. | $30^{1}$.7.Тарьц ургуулах, худалдан борлуулах, ойн үрийн нөөцийн улсын санд нийлүүлэх зориулалт бүхий үрээс дээж авч, үрийн чанарын шинжилгээг ойн үрийн төв лабораторид хийж, үрийн чанарын гэрчилгээ олгоно. | | |
| 3. | $30^{1}$.8.Гарал үүслийн болон чанарын гэрчилгээтэй ойн үржлийн материалыг худалдан борлуулна. | | |
| 4. | "38.5.Хушны самрын дунд ургацтай жилд зөвхөн ахуйн зориулалтаар, их ургацтай жилд аль ч зориулалтаар ашиглахыг зөвшөөрөх бөгөөд үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэсэн самрыг өөр сум, аймаг, хот руу тээвэрлэхэд энэ хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.11-д заасан гарал үүсэл, чанарын гэрчилгээ авна." | | |

Хуулийн этгээд, иргэн нь ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажилд гарал үүслийн болон чанарын гэрчилгээ авах тул стандарт ажиллагаа, зарцуулах хугацааг тооцьё.[2]

[1] "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал"-д заасны дагуу "гүйцэтгэх үүрэг" хэмээн үзэх үндэслэлгүй хэдий ч хуулийн төсөл батлагдсаны дараа хуулийн этгээд, иргэн заавал дагаж мөрдөх, үүний тул тодорхой хэмжээний зардал гарах тул тооцов.

[2] Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооноос аж ахуйн нэгж, байгууллагаас авсан зарцуулах хугацааны

| Агуулга | Стандарт ажиллагаа | Зарцуулах хугацаа (мин) |
| --- | --- | --- |
| -Гарал үүслийн гэрчилгээ авах<br>-Чанарын гэрчилгээ авах | Танилцах, судлах | 15 |
| | Мэдээлэл цуглуулах | 30 |
| | Өргөдөл хүсэлт гаргах | 30 |
| | Өгөгдөхүүнийг нягтлах | 20 |
| | Мөнгө шилжүүлэх | 10 |
| | **Дүн** | **105** |

"Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-д зааснаар хуулийн этгээд, иргэнд үүсэх зардалд захиргааны үүргийг гүйцэтгэхэд гарах зардлыг тооцдог. Иймд гарал үүслийн болон чанарын гэрчилгээ авахын тулд танилцах судлах, мэдээлэл цуглуулах, өргөдөл хүсэлт гаргах, өгөгдөхүүнийг нягтлах, мөнгө шилжүүлэх гэсэн таван стандарт ажиллагаа хийгдэх бөгөөд түүнд дунджаар 105 минут зарцуулахаар байна.

**1.2.Хуулийн этгээд, иргэнд үүсэх зардлыг тооцох**

Хуулийн этгээд, иргэнд үүсэх зардлыг стандарт ажиллагаанд зарцуулах хугацааг нэгж хугацааны ажлын хөлсөөр тооцож гаргадаг. Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагсдын сарын дундаж цалин 2018 оноос хойш улсын хэмжээнд нэг сая төгрөг, түүнээс дээш хэмжээтэй байна.[3]

| Ажиллагсдын цалин хөлс | 2018 он | 2019 он | 2020 он | Дундаж |
| --- | --- | --- | --- | --- |
| | | (төгрөг) | | |
| Улсын дундаж | 1,002,900 | 1,124,300 | 1,220,600 | 1,115,933 |

Ажиллагсдын сарын дундаж цалин сүүлийн жилд 100 орчим мянган төгрөгөөр нэмэгдсэн байх бөгөөд гурван жилийн дундаж цалин 1,115,933 төгрөг байна. Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу ажилтны долоо хоногийн ажлын цаг 40 хүртэл тул ажилтан сард ажлын 22 өдөр буюу нийт 176 цаг ажиллана.[4]

| Үндсэн цалин | Ажиллах хугацаа | Ажлын хөлс |
| --- | --- | --- |
| 1,115,933 | 176 цаг | 6,340.5 төг/цаг |
| 1,115,933 | 10,560 минут<br>(176 x 60 минут) | 105.7 төг/мин |

Ажилтны сарын дундаж цалинг сард ажиллах цагт тооцож үзвэл 6,340.5 төгрөг, сард ажиллах минутад тооцож үзвэл 105.7 төгрөг болно.

2 дугаар хүснэгт.Хуулийн этгээд, иргэний хийх стандарт ажиллагаа, зарцуулах хугацаа

| Агуулга | Стандарт ажиллагаа | Зарцуулах хугацаа (мин) | Ажлын хөлс (төгрөг) | Зардал (төгрөг) |
| --- | --- | --- | --- | --- |
| Гарал үүслийн гэрчилгээ авах, Чанарын гэрчилгээ авах | Танилцах, судлах | 15 | 105.7 | 1585.5 |
| | Мэдээлэл цуглуулах | 30 | 105.7 | 3171 |
| | Өргөдөл хүсэлт гаргах | 30 | 105.7 | 3171 |
| | Өгөгдөхүүнийг нягтлах | 20 | 105.7 | 2114 |

---

[3] Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, www.1212.mn

[4] Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 84.1-д "Долоо хоногийн ердийн ажлын цаг 40-өөс илүүгүй байна" гэж заасан

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Мөнгө шилжүүлэх | 10 | 105.7 | 1057 |
| | **Дүн** | **105** | | **11,098** |

Хуулийн этгээд, иргэн нь гарал үүслийн болон чанарын гэрчилгээ авахад хийгдэх таван стандарт ажиллагаанд 105 минут зарцуулах бөгөөд ажлын хөлсийг нь тооцож үзэхэд 11,098 төгрөг болно. Гарал үүслийн болон чанарын гэрчилгээг нэг жилд хэдэн хуулийн этгээд, иргэн авахыг тогтоосноор хуулийн этгээд, иргэнээс гарах нийт зардлын хэмжээг тооцох боломжтой.

2020 оны байдлаар улсын хэмжээнд 1342 ойн нөхөрлөл, 131 аж ахуйн нэгж, 651 ойн мэргэжлийн байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна.[5] Эдгээр байгууллага бүгд ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажил хийнэ хэмээн үзвэл тохиолдлын тоо нь 2124 болно, гарал үүслийн болон чанарын гэрчилгээг жилд нэг удаа авна хэмээн үзвэл давтамж нь нэг болж, тоон үзүүлэлт нь 2124 гарна. (1342 + 131 + 651 = 2124 *1 = 2124)

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр хуулийн этгээд, иргэнд хүлээлгэсэн ажил, стандарт үйл ажиллагаа нэг бүрийн зардлыг тоон үзүүлэлтээр үржүүлэн нийт зардлыг гаргана.



3 дугаар хүснэгт.Хуулийн этгээд, иргэнд үүсэх нэмэлт зардал

| **Агуулга** | **Стандарт ажиллагаа** | **Тоон үзүүлэлт** | **Зардал (төгрөг)** | **Нийт зардал (төг)** |
|---|---|---|---|---|
| Гарал үүслийн гэрчилгээ авах, Чанарын гэрчилгээ авах | Танилцах, судлах | 2124 | 1,585.5 | 3,367,602 |
| | Мэдээлэл цуглуулах | 2124 | 3,171 | 6,735,204 |
| | Өргөдөл хүсэлт гаргах | 2124 | 3,171 | 6,735,204 |
| | Өгөгдөхүүнийг нягтлах | 2124 | 2,114 | 4,490,136 |
| | Мөнгө шилжүүлэх | 2124 | 1,057 | 2,245,068 |
| | **Дүн** | | | **23,573,214** |

Урьдчилсан тооцоогоор ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажилд хэрэглэх модлог ургамлын үр, үржлийн материалд чанарын болон гарал үүслийн гэрчилгээ авахад 2124 хуулийн этгээд, иргэнээс нийт 23.5 сая төгрөгийн захиргааны нэмэлт зардал гарахаар байна. Эдгээрийг нэгжид хуваан үзвэл 11,098 төгрөг болно.Тодруулбал; нэг хуулийн этгээд, иргэнээс 11,098 төгрөгийн зардал нэг жилд гарах бөгөөд хүндрэл дарамт болохгүй хэмээн үзэж байна.

***Нэг хуулийн этгээд, иргэнд үүсэх нэмэлт зардлын урьдчилсан тооцоо: 11,098 (арван нэгэн мянга ерэн найман) төгрөг.***

## Хоёр.Төрийн байгууллагад үүсэх зардал

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцно. Төрийн байгууллагын зардлыг "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-ын дагуу үүргийг тогтоох, хүний нөөцийг тодорхойлох, гарах зардлыг тооцох, нийт зардлын дүнг тооцох, хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах гэсэн таван үе шатаар тооцож гаргана.

### 2.1.Төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг тогтоох

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлоход тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллагууд, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг

[5] Байгаль орчин, аялал жуулчлалын яам. Байгаль орчны төлөв байдлын 2020 ...

буюу ажил үйлчилгээ нэг бүрийг тодорхойлно. Байгууллагыг сонгохдоо тухайн ажил үйлчилгээнд хамааралтай бүх байгууллагыг бус голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох бөгөөд ажил үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг хамааруулна.

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг зарцуулах хугацаа болон тохиолдлын тоог тодорхойлох гэсэн хоёр дарааллаар тогтооно. ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр үүрэг хүлээсэн байгууллага нэг бүрийг; түүний гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг нэг бүрчлэн тодорхойлно. Гүйцэтгэх үүрэгт хуулиар олгогдсон бүртгэл хийх, зөвшөөрөл олгох зэрэг төрийн байгууллагаас үзүүлж байгаа ажил үйлчилгээг ойлгоно. Тохиолдын тоог нь тогтоох боломжгүй үйл ажиллагаа буюу хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, төрийн байгууллагын бодлого боловсруулах үүргийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцоонд оруулахгүй хэмээн аргачлалд заасан. 

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн ТЗТБ, ойн асуудал хариуцсан ТЗБ болон ойн үрийн төв лабораторид үүрэг хүлээлгэхээр байна.

4 дүгээр хүснэгт.Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг

| Д/д | Хуулийн төсөлд тусгасан төрийн байгууллагын үүрэг | Хэрэгжүүлэх төрийн байгууллага | Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ |
|---|---|---|---|
| 1. | 13.2.1.тариалангийн талбай, бэлчээр хамгаалах ойн зурвас байгуулах, жимс жимсгэнэ тариалах зэрэг агро-ойжуулалтыг бодлого, зохицуулалтаар хангах; | Хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн ТЗТБ | агро-ойжуулалтыг бодлого, зохицуулалтаар хангах |
| 2. | 13.2.2.мод боловсруулах салбарын үйл ажиллагааг бодлого, зохицуулалтаар хангах; | | бодлого, зохицуулалтаар хангах /мод боловсруулах салбар/ |
| 3. | 13.2.3.мод боловсруулах технологийн судалгаа, дамжуулалтад санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх; | | санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх /мод боловсруулах технологийн судалгаа, дамжуулалт/ |
| 4. | 13.2.4.ойн аж ахуйн салбарын ажилтныг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох журмыг батлах. | | журам батлах |
| 5. | 14.2.1.ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаарх хууль тогтоомж, эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; | Ойн асуудал хариуцсан ТЗБ | ойн талаарх хууль, төрийн байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах |
| 6. | 14.2.2.модлог ургамлын үрийн улсын нөөцийн сан байгуулах, тогтмол баяжуулах, үйл ажиллагааг нь хариуцах, үржлийн материал үйлдвэрлэх нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх; | | үрийн улсын нөөцийн сан байгуулах, үйл ажиллагааг нь эрхлэх, хэрэгжүүлэх |
| 7. | 14.2.3.үрийн удмын сангийн хадгаламж байгуулах, сорилт, туршилт судалгааны лаборатори ажиллуулах; | | хадгаламж байгуулах, лаборатори ажиллуулах |
| 8. | 14.2.4.улсын хэмжээнд ойн аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх, удирдан зохион байгуулах; | | ойн аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх |
| 9. | 14.2.5.ойн мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, мэдээллээр хангах; | | мэдээллийн сан бүрдүүлэх, хангах |

| | | | |
|---|---|---|---|
| 10. | 14.2.6.улсын ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах; | | ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжүүлэх |
| 11. | 14.2.7.ашиглалтын бүсийн ойн менежментийг сайжруулах, ойн нөөцийг иж бүрэн, хаягдалгүй ашиглахтай холбоотой ойн техник технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх; | Ойн асуудал хариуцсан ТЗБ | ойн менежментийг сайжруулах, ойн техник технологийг нэвтрүүлэх |
| 12. | 14.2.8.ойн тооллого, ой зохион байгуулалт хийх, ойн мониторингийн системийг хөгжүүлэх, ойн сангийн өөрчлөлтөд хяналт, шинжилгээ хийх; | | ойн тооллого, ой зохион байгуулалт хийх, ойн санд хяналт-шинжилгээ хийх |
| 13. | 14.2.9.ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, дүгнэлт гаргах; | | Ойн анги, ойн нөхөрлөл, ОМБ-д мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх |
| 14. | 14.2.10.ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, ашиглах зориулалтаар улсын төсвөөс олгосон хөрөнгийг хуваарилах, зарцуулалтад хяналт тавих, гүйцэтгэлийг тайлагнах; | | ойн зориулалтаар олгосон хөрөнгийг хуваарилах, хяналт тавих, тайлагнах |
| 15. | 14.2.11.модлог ургамлын үр, үржлийн материалын гарал үүслийн болон чанарын гэрчилгээний загварыг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах; | | гэрчилгээний загвар батлах |
| 16. | 14.2.12.улсын хэмжээнд хэрэгжүүлэх ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөж, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулж, санхүүжүүлэх; | | ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, төсөвт зардлыг тусгуулах, санхүүжүүлэх |
| 17. | 14.2.13.ой, хээрийн түймрийн аюултай үед ой, хээрийн түймрээс сэрэмжлүүлэх, эргүүл, харуул ажиллуулах, бүх нийтийг татан оролцуулах талаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах, түймрийн аюулын анги, зэрэглэлийг үндэслэн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт тодорхой үйл ажиллагааг зогсоох, хязгаарлах тухай саналыг аймаг, нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх; | Ойн асуудал хариуцсан ТЗБ | ой, хээрийн түймрийн үед орон нутгийн байгууллагатай хамтран ажиллах |
| 18. | 14.2.14.мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, говь, хээрийг ойжуулах, ойн зурвас байгуулах ажлыг төв, орон нутгийн түвшинд зохион байгуулах; | | ойжуулах, ойн зурвас байгуулах ажлыг зохион байгуулах |
| 19. | 14.2.15.ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой стандарт, журам, заавар боловсруулах, батлах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх; | | захиргааны акт боловсруулах, батлах |
| 20. | 14.2.16.ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал боловсруулах, батлах; | | захиргааны акт боловсруулах, батлах |

| | | | |
|---|---|---|---|
| 21. | 14.2.17.ой, хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг сурталчлах, иргэд, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг ой, хээрийн түймэр унтраах арга ажиллагаанд сургах ажлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх; | | ой, хээрийн түймрээс сэргийлэх ажлыг зохион байгуулах, төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах |
| 22. | 14.2.18.ой, хээрийн түймрийн гаралт, түүнээс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай зарлан мэдээлэх; | Ойн асуудал хариуцсан ТЗБ | ой, хээрийн түймрээс сэргийлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлэх |
| 23. | 14.2.19.ойн ангийн дүрмийг батлах, даргыг аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн томилох, чөлөөлөх. | | захиргааны акт батлах |
| 24. | $30^1$.2.Ойн үрийн мужлалын хилийн заагийг ойн шинжлэх ухааны байгууллагын саналыг үндэслэн тогтооно. | | захиргааны акт батлах |
| 25. | $30^1$.4.Модлог ургамлын үрийн нөөцийн улсын санг ойн үрийн төв лаборатори эрхэлнэ. | Ойн үрийн төв лаборатори | Үрийн нөөцийн улсын сан эрхлэх |
| 26. | $30^1$.7.Тарьц ургуулах, худалдан борлуулах, ойн үрийн нөөцийн улсын санд нийлүүлэх зориулалт бүхий үрээс дээж авч, үрийн чанарын шинжилгээг ойн үрийн төв лабораторид хийж, үрийн чанарын гэрчилгээ олгоно. | | Дээж авах, үрийн чанарын шинжилгээ хийх, үрийн чанарын гэрчилгээ олгох |

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр төрийн байгууллагад хүлээлгэсэн 26 үүргийг одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа ОтХ-тай харьцуулан үзье.

5 дугаар хүснэгт.Төрийн байгууллагын үүргийн харьцуулалт /төсөл болон ОтХ/

| Д/д | Төрийн байгууллагын үүрэг | ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл | ОтХ | Тайлбар |
|---|---|---|---|---|
| **Хэрэгжүүлэх субъект.Хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн ТЗТБ** | | | | |
| 1. | тариалангийн талбай, бэлчээр хамгаалах ойн зурвас байгуулах, жимс жимсгэнэ тариалах зэрэг агро-ойжуулалтыг бодлого, зохицуулалтаар хангах; | 13.2.1 | - | Шинээр нэмэгдсэн. |
| 2. | мод боловсруулах салбарын үйл ажиллагааг бодлого, зохицуулалтаар хангах; | 13.2.2 | - | |
| 3. | мод боловсруулах технологийн судалгаа, дамжуулалтад санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх; | 13.2.3 | - | |
| 4. | ойн аж ахуйн салбарын ажилтныг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох журмыг батлах. | 13.2.4 | - | |
| **Хэрэгжүүлэх субъект.Ойн асуудал хариуцсан ТЗБ** | | | | |
| 5. | ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх, ургуулах талаарх хууль тогтоомж, эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; | 14.2.1 | 13.1.1 | Өөрчлөлт ороогүй. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6. | модлог ургамлын үрийн улсын нөөцийн сан байгуулах, тогтмол баяжуулах, үйл ажиллагааг нь хариуцах, үржлийн материал үйлдвэрлэх нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх; | 14.2.2 | 13.1.20 | Өөрчлөн найруулсан. |
| 7. | үрийн удмын сангийн хадгаламж байгуулах, сорилт, туршилт судалгааны лаборатори ажиллуулах; | 14.2.3 | 13.1.34 | Өөрчлөн найруулсан. |
| 8. | улсын хэмжээнд ойн аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх, удирдан зохион байгуулах; | 14.2.4 | - | Шинээр нэмэгдсэн. |
| 9. | ойн мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, мэдээллээр хангах; | 14.2.5 | 13.1.9, 13.1.25 | Өөрчлөн найруулсан. |
| 10. | улсын ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах; | 14.2.6 | 13.1.18 | Өөрчлөн найруулсан. |
| 11. | ашиглалтын бүсийн ойн менежментийг сайжруулах, ойн нөөцийг иж бүрэн, хаягдалгүй ашиглахтай холбоотой ойн техник технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх; | 14.2.7 | - | Өөрчлөн найруулсан. |
| 12. | ойн тооллого, ой зохион байгуулалт хийх, ойн мониторингийн системийг хөгжүүлэх, ойн сангийн өөрчлөлтөд хяналт, шинжилгээ хийх; | 14.2.8 | 7.1, 7.2, 13.1.25 | Өөрчлөн найруулсан. |
| 13. | ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, дүгнэлт гаргах; | 14.2.9 | 13.1.21 | Өөрчлөн найруулсан. |
| 14. | ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, ашиглах зориулалтаар улсын төсвөөс олгосон хөрөнгийг хуваарилах, зарцуулалтад хяналт тавих, гүйцэтгэлийг тайлагнах; | 14.2.10 | 13.1.23 | Өөрчлөн найруулсан. |
| 15. | модлог ургамлын үр, үржлийн материалын гарал үүслийн болон чанарын гэрчилгээний загварыг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах; | 14.2.11, 23.5 | 22.3 | Өөрчлөн найруулсан. |
| 16. | улсын хэмжээнд хэрэгжүүлэх ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөж, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулж, санхүүжүүлэх; | 14.2.12. | 13.1.11 | Өөрчлөн найруулсан. |
| 17. | ой, хээрийн түймрийн аюултай үед ой, хээрийн түймрээс сэрэмжлүүлэх, эргүүл, харуул ажиллуулах, бүх нийтийг татан оролцуулах талаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах, түймрийн аюулын анги, зэрэглэлийг үндэслэн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт тодорхой үйл ажиллагааг зогсоох, хязгаарлах тухай саналыг аймаг, нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх; | 14.2.13. | 13.1.31 | Өөрчлөлт ороогүй. |
| 18. | мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, говь, хээрийг ойжуулах, ойн зурвас байгуулах ажлыг төв, орон нутгийн түвшинд зохион байгуулах; | 14.2.14 | 13.1.19 | Өөрчлөн найруулсан. |
| 19. | ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой стандарт, журам, заавар | 14.2.15 | 13.1.24 | Өөрчлөн найруулсан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | боловсруулах, батлах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх; | | | |
| 20. | ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал боловсруулах, батлах; | 14.2.16. | 13.1.27 | Өөрчлөн найруулсан. |
| 21. | ой, хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг сурталчлах, иргэд, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг ой, хээрийн түймэр унтраах арга ажиллагаанд сургах ажлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх; | 14.2.17. | 13.1.29 | Өөрчлөлт ороогүй. |
| 22. | ой, хээрийн түймрийн гаралт, түүнээс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай зарлан мэдээлэх; | 14.2.18 | 13.1.33 | Өөрчлөлт ороогүй. |
| 23. | ойн ангийн дүрмийг батлах, даргыг аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн томилох, чөлөөлөх. | 14.2.19. | 13.1.22, 17.2.8 | Өөрчлөн найруулсан. |
| 24. | Ойн үрийн мужлалын хилийн заагийг ойн шинжлэх ухааны байгууллагын саналыг үндэслэн тогтооно. | $30^1$.2. | | Шинээр нэмэгдсэн. |
| **Хэрэгжүүлэх субъект.Ойн үрийн төв лаборатори** | | | | |
| 25. | Модлог ургамлын үрийн нөөцийн улсын санг ойн үрийн төв лаборатори эрхэлнэ. | $30^1$.4. | 13.1.20 | Өөрчлөн найруулсан. |
| 26. | Тарьц ургуулах, худалдан борлуулах, ойн үрийн нөөцийн улсын санд нийлүүлэх зориулалт бүхий үрээс дээж авч, үрийн чанарын шинжилгээг ойн үрийн төв лабораторид хийж, үрийн чанарын гэрчилгээ олгоно. | $30^1$.7. | - | Өөрчлөн найруулсан. |

Дээр дурдсан 26 үүргээс 20-д нь өөрчлөлт ороогүй эсхүл, өөрчлөн найруулсан үүрэг бол зургаа нь шинээр нэмэгдсэн үүрэг болно. Шинээр нэмэгдсэн зургаан үүргээс дөрвөн үүргийг хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн ТЗТБ, хоёр үүргийг ойн асуудал хариуцсан ТЗБ гүйцэтгэнэ.

"Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-д зааснаар төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэгт тохиолдлын тоог нь тогтоох боломжтой хуулиар олгогдсон бүртгэл хийх, зөвшөөрөл олгох зэрэг төрийн байгууллагаас үзүүлж байгаа ажил үйлчилгээг хамруулна. Тохиолдлын тоог нь тогтоох боломжгүй буюу төрийн байгууллагын бодлогын шинжтэй ажил үйлчилгээ (хуулийн төсөл, захиргааны актын төсөл боловсруулах, хэлэлцэх, батлах зэрэг), хяналт тавих зэрэг үүргийг зардлын тооцоонд оруулдаггүй болно. Төрийн байгууллагад шинээр нэмэгдсэн зургаан үүргийг аргачлалд заасны дагуу төрийн байгууллагаас үзүүлж байгаа ажил үйлчилгээ болон бодлогын шинжтэй үүргээр нь авч үзье.

6 дугаар хүснэгт.Төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийн төрөл

| Д/д | Төрийн байгууллагын үүрэг | Тохиолдлын тоог нь тогтоох боломжтой үүрэг | Тохиолдлын тоог нь тогтоох боломжгүй үүрэг |
|---|---|---|---|
| | | (ажил үйлчилгээ) | (бодлогын, хяналтын үүрэг) |
| **Хэрэгжүүлэх субъект.Хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн ТЗТБ** | | | |

| | | | |
|---|---|---|---|
| 1. | тариалангийн талбай, бэлчээр хамгаалах ойн зурвас байгуулах, жимс жимсгэнэ тариалах зэрэг агро-ойжуулалтыг бодлого, зохицуулалтаар хангах; | | + |
| 2. | мод боловсруулах салбарын үйл ажиллагааг бодлого, зохицуулалтаар хангах; | | + |
| 3. | мод боловсруулах технологийн судалгаа, дамжуулалтад санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх; | | + |
| 4. | ойн аж ахуйн салбарын ажилтныг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох журмыг батлах. | | + |
| **Хэрэгжүүлэх субъект.Ойн асуудал хариуцсан ТЗБ** | | | |
| 5. | улсын хэмжээнд ойн аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх, удирдан зохион байгуулах; | | + |
| 6. | ойн үрийн мужлалыг тогтоох | | + |
| | **Дүн** | | **6** |

Хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн ТЗТБ, ойн асуудал хариуцсан ТЗБ-д шинээр нэмэгдэх зургаан үүрэг нь бүгд бодлогын шинжтэй үүрэг тул аргачлалд заасны дагуу эдгээр үүргийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцох шаардлагагүй байна.

**2.2.Ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох**

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан ойн асуудал хариуцсан ТЗБ-ын үүргийг судалж үзэхэд Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Ойн судалгаа хөгжлийн төвийн гүйцэтгэдэг үүрэг байх бөгөөд шинээр нэмэгдсэн үүрэг, ажил үйлчилгээ байхгүй болно. ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд "... Ойн асуудал хариуцсан ТЗБ-ыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дотоод бүтэц дэх Ойн бодлого зохицуулалтын газар болон Ойн судалгаа хөгжлийн төвд ажиллаж байгаа орон тооны дийлэнх хэсгийг шинээр байгуулагдах бүтцэд шилжүүлж, төсөвт дарамт үүсгэхгүйгээр батлагдсан төсөвт багтаан сэргээн байгуулна" гэж тусгасан.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ойн бодлого зохицуулалтын газар 8, Ойн судалгаа хөгжлийн төв 12 орон тоотой ажилладаг. Ойн асуудал хариуцсан ТЗБ-ын орон тооны хязгаарыг 12 байхаар Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд тусгасан. Хуулийн төслөөр ойн асуудал хариуцсан ТЗБ-д хүлээлгэх үүрэг нь одоогоор хийгддэг бөгөөд шинэ ажил үйлчилгээ биш тул Ойн бодлого зохицуулалтын газар болон Ойн судалгаа хөгжлийн төвийн орон тоо, ажилтнуудыг холбогдох эд хөрөнгө, төсвийн хамт шинээр байгуулагдах агентлагт шилжүүлэх асуудал үүснэ. Иймд одоо байгаа орон тоог нэмэхгүйгээр бүтэц, зохион байгуулалтын зохих өөрчлөлтөөр шийдвэрлэх боломжтой.

**2.3.Гарах зардлыг тооцох**

"Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалд"-д хүний нөөцийн, материаллаг болон бусад зардлыг зардалд тооцохоор заасан. Хүний нөөцийн зардалд тухайн үүргийг гүйцэтгэх төрийн албан хаагчийн цалин, нэмэгдэл, тусламж, төрөөс хариуцах зардал; материаллаг зардалд тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардал буюу ажлын байрны, хөрөнгийн элэгдэл хорогдлын, цахилгаан дулааны, бичиг хэргийн, техник, тоног төхөөрөмжийн, хөрөнгө оруулалтын зардал; бусад зардалд тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах зардлыг үздэг. ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр төрийн байгууллагад шинээр үүрэг хүлээлгээгүй тул хүний нөөцийн, материаллаг, бусад зардлын аль аль нь нэмэгдэхгүй.

Гэхдээ ойн асуудал хариуцсан ТЗБ байгуулагдахтай холбогдуулан зарим зардал гарч болзошгүй. Материаллаг зардлын бүрэлдэхүүнд ордог ном хэвлэл, бага үнэтэй

түргэн элэгдэх эд зүйл (цэвэрлэгээний материал), урсгал засвар, нэг удаагийн зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, тээврийн хэрэгслийн болон бусад татвар, төлбөр, хураамж, аудитын төлбөр зэрэг зардлыг холбогдох байгууллагын төсвөөс шилжүүлэх замаар шийдвэрлэнэ. Харин ажлын байрны, цахилгааны дулааны, хэвлэмэл хуудас болон тамга хийлгэх зэрэг зардал гарна. Ойн судалгаа хөгжлийн төвийн 2021 оны батлагдсан төсвийн мэдээлэлд үндэслэн гарч болзошгүй нэмэлт зардлыг тооцьё.[6]

7 дугаар хүснэгт.Төрийн байгууллагын нэмэлт зардлын тооцоо



| Д/д | Зардлын төрөл | Зардлын дүн (мян.төг) | Гарах зардлын хэмжээ (мян.төг) | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1. | Байр ашиглалт | 7,992.8 | 3,996.4 | 2021 оны дүнг 12 хүнд гарсан зардал хэмээн үзэж, 50 хувиар нэмэгдэнэ хэмээн тооцов. |
| 2. | Гэрэл цахилгаан | 625.0 | 312.5 | 2021 оны дүнг 12 хүнд гарсан зардал хэмээн үзэж, 50 хувиар нэмэгдэнэ хэмээн тооцов. Түүнчлэн төрөөс үзүүлэх хөнгөлөлтийн хугацаа дууссан тул цахилгааны зардал үндсэн тарифаар гарна. |
| 3. | Түлш, халаалт | 7,367.8 | 3683.9 | 2021 оны дүнг 12 хүнд гарсан зардал хэмээн үзэж, 50 хувиар нэмэгдэнэ хэмээн тооцов. |
| 4. | Хэвлэмэл хуудас, тамга, хаяг | | 1,000.0 | Албан бичиг, захирамжлалын баримт бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдэг шинээр хийлгэнэ гэж тооцов. |
| 5. | Нүүлгэлт | | 600.0 | Нүүлгэлтийн компаниас авсан үнийн судалгаанд үндэслэв. |
| 6. | **Нийт** | | **9,592.8** | |

Ойн бодлого зохицуулалтын газар, Ойн судалгаа хөгжлийн төв нь ойн асуудал эрхэлсэн ТЗБ болж зохион байгуулагдан хоёр өөр байршилд бус нэг байршилд үйл ажиллагаагаа явуулах нөхцөлд байр ашиглалтад хамаарах зардал нэмэгдэж гарна. Байр ашиглалтын зардлаас бусад зардлыг төсвийн хамт шилжүүлэх боломжтой. Урьдчилсан тооцоогоор байр ашиглалт, бичиг хэрэг болон нүүлгэлтэд нийт 9.5 сая төгрөгийн зардал гарахаар байна.

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн $30^1$.5-д модлог ургамлын үр, үржлийн материалын үйлдвэрлэл төрийн ивээлд байх бөгөөд төрөөс шилмэл болон сортын үр, тарьц, суулгац үйлдвэрлэхэд хөрөнгө оруулалт хийх, үнийн зохицуулалт хийх, урамшуулал олгох, шилмэл болон сортын үр үйлдвэрлэхэд гарсан зардлын тодорхой хэсгийг нөхөн олгох, хөнгөлөлттэй зээл олгох зэрэг замаар дэмжлэг үзүүлнэ хэмээн тусгасан. Төрөөс модлог ургамлын үр, үржлийн материал бэлтгэх, импортлох, экспортлох, үрийн улсын нөөцийн сан бүрдүүлэх журмыг байгаль орчны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална гэжээ. Төрөөс модлог ургамлын үр, үржлийн материалын үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх журмыг нарийвчлан тогтоох эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдад олгожээ. ОтХ-ийн төсөл батлагдсаны дараа журам батлах эсэх нь тодорхой болж, журмаар төрөөс олгох дэмжлэгийн хэмжээг тогтоох тул дэмжлэгэд гарах зардлыг одоогоор тооцох боломжгүй

6 Шилэн данс цахим хуудас, https://www.shilendans.gov.mn/org/958?form=4917073&year=2021&month=12&group=0&task=2083

юм. Түүнчлэн "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалд"-д төрийн байгууллагаас гарах захиргааны зардлыг тооцохоор тусгасан болно.

**2.4.Нийт зардлын дүнг тооцох**

Зардал нь хүний нөөцийн, материаллаг болон бусад зардлаас бүрдэх талаар өмнө дурдсан. Хүний нөөцийн болон бусад зардал нэмэгдэхгүй бөгөөд нийт зардал нь зөвхөн материаллаг зардал болно. ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр төрийн байгууллагад шинээр үүрэг хүлээлгээгүй тул үүнтэй холбоотой нэмэгдэх зардал байхгүй. Харин ойн асуудал хариуцсан ТЗБ шинээр зохион байгуулагдахтай холбоотой материаллаг зардал гарч болзошгүй. Энэ нь 9.5 сая төгрөг болно. Тодруулбал; нийт зардлын дүн 9.5 сая төгрөг юм. 15

**2.5.Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах**

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр шинээр нэмж байгаа буюу өөрчилж байгаа зохицуулалттай холбогдон гарах төсвийг багасгах, эдийн засагт дарамт багатай өөр хувилбар байгаа эсэхийг нягтална. ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэрэгжсэнээр гарах 9.5 сая төгрөгийн зардал нь байр ашиглалтын зардал юм. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ойн бодлого зохицуулалтын газар болон Ойн судалгаа хөгжлийн төв нь одоогийн байранд үйл ажиллагаагаа явуулах нөхцөлд дээр дурдсан байр ашиглалтын зардал гарахгүй. Гэхдээ энэ хувилбар нь ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгжилтэд эерэг нөлөө үзүүлэх магадлал бага болно.

***Төрийн байгууллагад үүсэх нэмэлт зардлын урьдчилсан тооцоо: 9.5 сая төгрөг.***

## САНАЛ ЗӨВЛӨМЖ

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-ын дагуу зардлын тооцоо хийв. Хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад дараах нэмэлт зардал, ачаалал үүсэх урьдчилсан тооцоо гарч байна:

-Нэг хуулийн этгээд, иргэнд 11,098 төгрөгийн зардал;
-Төрийн байгууллагад 9.5 сая төгрөгийн зардал.

Төрийн нийтийн өмч болох ой, түүний дагалдах баялагийг нэмэгдүүлэх, байгаль орчин, уур амьсгалд үзүүлэх эерэг нөлөөллийг дэмжихэд ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ач холбогдол их болно. Иймд уг хуулийн төслийн зорилготой харьцуулахад хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагаас гарч болзошгүй нэмэлт зардлын хэмжээ бага буюу тэдэнд хүндрэл үүсгэхгүй хэмээн үзэж байна. Тодруулбал; хуулийн этгээд, иргэнээс гарч болзошгүй зардлын хэмжээ бага, төрийн байгууллагаас гарч болзошгүй зардал нь нэг удаагийн шинжтэй, хуулийн төсөл батлагдсанаар гарах үр өгөөж өндөр болно. Ойн асуудал хариуцсан ТЗБ байгуулагдахтай холбоотой нэмэлт зардал нь зөвхөн эхний жилд буюу нэг удаа гарах бөгөөд дараагийн жилд гарахгүй зардал юм.

***Хуулийн этгээд, иргэн, төрд үүсэж болзошгүй нэмэлт зардал нь дарамт учруулах хэмжээнд бус хэмээн үзэж байна.***

ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр төрийн байгууллагад шинээр үүрэг хүлээлгээгүй, хуулийн этгээд, иргэний үүргийг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-д зааснаар үүрэг хэмээн тооцох үндэслэлгүй болохыг дурдая.

***ОтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлан хэрэгжүүлснээр хуулийн этгээд, иргэн, төрд үүсэх зардал бага, гарах өгөөж өндөр болно.***

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ


1.Ойн тухай хууль;

2.Хөдөлмөрийн тухай хууль;

3.Хууль тогтоомжийн тухай хууль;

4.Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал";

5.Монгол Улсын байгаль орчны төлөв байдлын 2020 оны тайлан;

6.Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, legalinfo.mn;

7.Ойн судалгаа хөгжлийн төвийн цахим хуудас, www.forestry.gov.mn;

8.Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, www.1212.mn;

9.Шилэн данс, www.shilendans.gov.mn.

1 дүгээр хавсралт

# ОЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТЭМДЭГЛЭЛ

2022.02.28.

| | |
|---|---|
| Зохион байгуулагч: | Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ойн бодлого зохицуулалтын газар |
| Оролцогчид: | Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагын ажилтан, албан хаагчид |
| Оролцогчдын тоо: | 36 |



Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2022.02.28-ны өдрийн 16.00-17.30 цагт цахим хэлбэр (zoom)-ээр зохион байгуулав. Хэлэлцүүлгийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ойн бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн, доктор Ц.Чулуунбаатар удирдан явуулсан.

Хуулийн төсөл боловсруулахад зөвлөх үйлчилгээ үзүүлсэн "Өмгөөллийн ивээл баг" хуулийн нөхөрлөлийн төлөөлөл хуулийн төслийн танилцуулга хийв. Зөвлөх үйлчилгээ үзүүлсэн байгаль орчны гавьяат ажилтан, доктор Ц.Банзрагч хэлэлцүүлэгт оролцогчдын санал хүсэлтэд хариулт тайлбар өгөв. Хэлэлцүүлэгт оролцогчдын гаргасан зарчмын өөр саналыг нэгтгэн танилцуулья.

| Д/д | Санал гаргасан субъект | Саналын агуулга | Тайлбар |
|---|---|---|---|
| 1. | н.Жүгдэргарав, ойн мэргэжлийн байгууллага, Архангай | Мэргэжлийн мод үржүүлгийн газруудыг плантаци хэлбэрээр байгуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжих арга хэмжээ авах зохицуулалт тусгах саналтай. Ойн тухай хуулийн төслийг дэмжиж байна. | Үндэсний стратеги төлөвлөгөө хийгдэж байна. Байгалийн сэргэн ургалтыг дэмжих арга хэмжээ авна. Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд энэ талаар тусгагдаагүй болно. Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах, яригдах үед авч үзэх боломжтой. |
| 2. | н.Ариунжаргал, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Завхан | Ойн агентлаг байгуулагдах, хуулийн төслийг бүхэлд нь дэмжиж байна. Ойн агентлаг байгуулагдахаар орон нутгийн түвшинд салбар нэгж нь хэрхэн ажиллах вэ? Босоо тогтолцоотой болох уу? | Хуулийн төсөлд Ойн агентлагийн дарга нь ойн ангийн даргыг аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлөхөөр тусгасан. Орон нутаг зарим төсвийг хариуцах үүрэгтэй бол орон нутагтай зөвшилцөх шаардлагатай болно. |

| | | | |
|---|---|---|---|
| 3. | н.Хадбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хөвсгөл | Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжиж байгаа, тусгайлан өгөх саналгүй. Ойн тухай хуулийн 31.4-т иргэн бүр мод тарих үүрэгтэй гээд энэ үүргээ биелүүлээгүй нөхцөлд зардлыг хандивлана гэсэн зохицуулалт бий. Хандивын хэмжээг тогтоох эрх аймгийн ИТХ-д байдаггүй. Аймаг хандивын хэмжээ тогтоосон шийдвэр гаргасан боловч Хууль зүйн яам шаардлага хангахгүй байна, хуулиар эрх олгогдоогүй гэж үзээд бүртгээгүй. Иймд жишиг байдлаар хуульд тусгах боломжтой байна уу?<br><br>Ойн тухай хуулийн 34.1-т ойн анги гээд ойн анги байхгүй бол сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан гэж заасан. Эрх бүхий албан тушаалтан нь хэн болохыг хуульд тодорхой тусгах. | **Саналыг хүлээн авч, хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт болгон нэмж оруулсан.** |
| 4. | н.Бурмаа, сум дундын ойн ангийн дарга, Өмнөговь | Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд тусгагдсан дөрвөн зарчмын саналтай танилцсан, дэмжиж байгаа. Тарьц, суулгацаа зараад орлого төвлөрүүл гэдэг үүрэг өгдөг. Суулгацын үнийг хэн, хэрхэн тогтоох асуудал тодорхой бус байна. Үнийг асуудлыг зохицуулсан тусгай журамтай байх. | Хуулийн төслийн үзэл баримтлалд энэ асуудал тусгагдаагүй. Тарьц, суулгацын үнийн асуудал зах зээлийн горимоор шийдэгдэнэ. |
| 5. | н.Оюунцэцэг, ойн мэргэжлийн байгууллага | Модлог ургамлын үр, үржлийн материалын зохицуулалт маш чухал тул дэмжиж байна. Ойн тухай хуулийг шинэчлэн | Магадлан итгэмжлэл нь зөвшөөрлийн тогтолцоог өөрчлөх зохицуулалт юм. Хуулийн төсөлд тусгаснаар магадлан итгэмжлэлий |

| | | | |
|---|---|---|---|
| | | найруулах шаардлагатай. Ойн байгууллагын магадлан итгэмжлэлийн асуудал тусгагджээ. Яамнаас эрхээ авсан мод үржүүлгийн газрууд яах вэ? Эрхээ авсан ч гэсэн магадлан итгэмжлэлд хамрагдах уу? | төрийн бус байгууллага гүйцэтгэх бөгөөд тэдний дүгнэлтийг үндэслэн ойн мэргэжлийн байгууллага гэсэн гэрчилгээг ойн агентлаг олгоно. Мод үржүүлгийн газраа байгуулаад ажиллах, харин улс, орон нутгийн төсвөөс санхүүжилт авах бол магадлан итгэмжлэлд хамрагдана. |
| 6. | н.Бүрэнбат, Дархан-Уул | Ойн агентлаг байгуулагдахыг дэмжиж байгаа, хуулийн төслийг бүхэлд нь дэмжиж байгаа. Ойн агентлаг нэг байгуулагдаад нэг татан буулгаад байдаг нь ямар учир шалтгаантай вэ? Тэрбум мод үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлүүд хэдэн хувийн модыг нь тарих вэ? Энэ талын тооцоо судалгаа хийсэн үү? Сургалтын асуудал чухал байдаг. Сүүлийн үед сургалт хийгдэхгүй байгааг анхаарах. | "Тэрбум мод" хөдөлгөөнийг хэрэгжүүлэх тооцоо судалгаа хийгдэж байна. Мөн үндэсний стратегийг боловсруулах ажил хийгдэж байна. |
| 7. | н.Төгсөө, Дорноговь | Мод тарихад ашиглаж байгаа хөрөнгийг татвараас чөлөөлөхгүй асуудал үүсэж байна. НҮБ-тай байгуулсан гэрээнд татвар төлөхгүй гэж тусгасан боловч татварын байгууллага шалгаад татвар төлнө гэдэг. Түүнчлэн 3 хувийн татварын хөнгөлөлт үзүүлэх хуулийн зохицуулалттай ч бодит амьдрал дээр хэрэгжихгүй байна. | Хуулиар нэгэнт зохицуулагдсан асуудал болно. Хөнгөлөлт хэрэгжиж байгаа, аль нэг талд үл ойлголцсон асуудал гарсан байх магадлалтай. |
| 8. | н.Эрдэнэцогт, Сэлэнгэ | Ойн агентлаг байгуулах нь цаг үеэ олсон чухал ажил юм. Манай аймагт гэхэд | "Тэрбум мод" хөдөлгөөнийг хэрэгжүүлэх тооцоо судалгаа хийгдэж |

| | | | |
|---|---|---|---|
| | | ойн анги нь улсын төсөвт үйлдвэрийн газар гэсэн статустай байдаг. Хэрвээ орон нутгийн төсөвт болох нөхцөлд санхүүжилтэд хүндрэл гарах эрсдэлтэй. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хэрэгжилтэд зохицуулалт шаардлагатай байна. Хүмүүс хаа сайгүй хөрөө, хайч бариад мод мөчир тайрах хандлага гарч байна. Түүнчлэн ойн зээл, ногоон зээлийн асуудал хэрэгцээтэй байна. | байна. Мөн үндэсний стратегийг боловсруулах ажил хийгдэж байна. |



**Дүгнэлт**:

1.Хэлэлцүүлэгт оролцогчид бүгд Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь дэмжиж байгаагаа илэрхийлсэн;

2.Хэлэлцүүлэгт оролцогчдын зарчмын өөр саналыг дээрх хүснэгтэд танилцуулав.

2 дугаар хавсралт



**ОЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ СУДАЛГАА**

2022.02.28

**Танд энэ өдрийн мэнд хүргэе.**

**Судалгаанд оролцогчид: Аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Ойн анги, Ойн мэргэжлийн байгууллага, Ойн нөхөрлөл, ойн салбарын ажилтан, албан хаагчид.**

Судалгаанд оролцох заавар: Та зөвхөн нэг хариулт ✓ тэмдэг тавих/ өгөх бөгөөд хэрвээ Та бусад хэсгийг сонгох нөхцөлд өөрийн саналаа бодлоо нээлттэй, үндэслэлтэй илэрхийлнэ үү. Энэ нь судалгааны ажилд эерэг нөлөө үзүүлнэ.

**Та бүхнийг судалгаанд идэвхтэй оролцохыг хүсье.**

Нэг.Ерөнхий мэдээлэл

| Таны ажил эрхлэлт? | БОАЖГ | Ойн анги | ОМБ | ОН | Бусад | Мод үржүүлгийн газар | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 5 | 6 | 1 | | | 1 | 13 |

| Зохицуулалтын агуулга | Асуултын тоо | Асуулт | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага | 20 | Зорилгод хүрэх байдал | | Практикт хэрэгжих боломж | | Хүлээн зөвшөөрөгдөх байдал |
| Ойн байгууллагын магадлан итгэмжлэл | 6 | Зорилгод хүрэх байдал | | Практикт хэрэгжих боломж | | Ойлгомжтой томьёологдсон байдал |
| Модлог ургамлын үр, үржлийн материал | 19 | Зорилгод хүрэх байдал | | Практикт хэрэгжих боломж | | Ойлгомжтой томьёологдсон байдал |
| Ойн дагалт баялагийг ашиглах горим | 1 | X | | Практикт хэрэгжих боломж | | Ойлгомжтой томьёологдсон байдал |
| Дүн | 46 | | | | | |

Хоёр.Үндсэн судалгаа

| Д/д | Зохицуулалтын агуулга | Д/д | Хуулийн төслийн зохицуулалт | Асуулт | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 14.2.Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ойг хамгаалах, нөхөн сэргээх, ашиглах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ | Ойн агентлаг төсөлд тусгагдсан бүрэн эрхээ хэрэгжүүлснээр зорилгод хүрэх эсэх байдлыг хэрхэн үнэлэх вэ? | | | | | Ойн агентлаг бүрэн эрхээ практикт хэрэгжүүлэх боломжтой эсэхийг хэрхэн үнэлэх вэ? | | | | | Ойн агентлагийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хэрхэн үнэлэх вэ? | | | |
| | | 1 | 14.2.1.ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаарх хууль тогтоомж, эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; | Тийм | Дундаж | Үгүй | Бусад | | Тийм | Дундаж | Үгүй | Бусад | | Хангалттай | Дунд | Хангалтгүй | Бусад |
